

VŠEOBECNÉ OBCHODNÍ PODMÍNKY

společnosti **MONTO, s.r.o.**,
IČO 251 85 799, se sídlem Žerotínova 503/5,
České Budějovice 4, 370 04 České Budějovice,
zapsané v obchodním rejstříku vedeném
Krajským soudem v Českých Budějovicích, oddíl
C, vložka 8446 (dále jen „**Společnost**“),

pro poskytování služeb prostřednictvím
internetového portálu SimpleGate umístěného
na internetové adrese www.simplegate.eu

1. Úvodní ujednání

1.1. Společnost poskytuje služby spočívající
v základní inzerci volných pracovních míst v
členských státech Evropské unie (dále jen
„**Základní databáze**“), poskytování bližších
informací o volných pracovních místech
v členských státech Evropské unie (dále jen
„**Rozšířená databáze**“), poskytování
komparace profilu Uživatele s volnými
pracovními pozicemi a shrnutí formou
seznamu (dále jen „**Párování nabídek**“),
a zprostředkování informací o postupu pro
získání pracovního a pobytového
oprávnění nebo jiného obdobného
povolení v členských státech Evropské
unie, které Registrovaný uživatel vybral při
provádění registrace (dále jen „**Informace
o imigračních povoleních**“) (Základní
databáze, Rozšířená databáze, Párování
nabídek a Informace o imigračních
povoleních společně dále jen jako
„**Služby**“).

1.2. Služby jsou poskytovány
prostřednictvím internetového portálu
SimpleGate dostupného na adrese:
www.simplegate.eu (dále jen „**Webové
stránky**“).

1.3. Společnost je pořizovatelem Základní
databáze a Rozšířené databáze
zveřejněných prostřednictvím Webových
stránek.

МОНТО ХХК (MONTO, s.r.o.) -ийн ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Ческе Будееовице хот дахь Аймгийн шүүхийн
Аж ахуйн нэгжийн бүртгэлийн С хэсгийн 8446
дугаарт бүртгэгдсэн, улсын бүртгэлийн 251 85
799 дугаартай, Ческе Будееовице 4-р дүүрэг,
Жеротинова гудамжны 503/5 тоот хаяг, 370 04
шуудангийн дугаартай МОНТО ХХК (цаашид
"Компани" гэх) компанийн
www.simplegate.eu интернет хаягт байрлах
SimpleGate интернет порталаар дамжуулан
үйлчилгээ үзүүлэх ерөнхий нөхцөл

1. Ерөнхий зүйл

1.1. Тус компани нь Европын Холбооны
гишүүн орнууд дахь нээлттэй ажлын байрны
зар (цаашид „**Үндсэн мэдээллийн сан**“ гэх),
холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг
үйлчилгээг үзүүлдэг. (цаашид „**Өргөтгөсөн
мэдээллийн сан**“ гэх) холбооны улсуудын
хэмжээнд түгээх сурталчлах, Хэрэглэгчийн
профайлыг зарлагдаж буй ажлын байртай
харьцуулах, боломжтой ажлын байруудыг
нэгтгэж санал болгох (цаашид „**Тохируулах,
санал болгох**“ гэх), бүртгэгдсэн хэрэглэгчийн
сонгосон Европын Холбооны гишүүн оронд
ажиллах, оршин суух болон бусад зөвшөөрөл
авах журмын (цаашид „**Цагаачлал буюу
шилжин суурьшилтын зөвшөөрөл хүсэх,
олгох тухай мэдээлэл**“ гэх) талаар мэдээлэл
олгох (цаашид Үндсэн мэдээллийн сан,
Өргөтгөсөн мэдээллийн сан, Тохируулах,
санал болгох мөн Цагаачлал буюу шилжин
суурьших зөвшөөрөл хүсэх, олгох тухай
мэдээллийг хамтад нь „**Үйлчилгээ**“ гэх) зэрэг
үйлчилгээ үзүүлнэ.

1.2. Дээр заасан үйлчилгээг SimpleGate
интернет порталаар дамжуулан
www.simplegate.eu (цаашид „**Веб сайт**“ гэх) -
аар үзүүлнэ.

1.3. Компани нь Веб сайтаар түгээх Үндсэн
мэдээллийн сан болон Өргөтгөсөн
мэдээллийн сангийн ханган нийлүүлэгч юм.

- 1.4. Společnost poskytuje Služby výhradně zájemcům o zaměstnání ze zemí mimo Evropskou unii, kteří nejednají v rámci své podnikatelské činnosti nebo v rámci svého samostatného výkonu povolání (dále jen „**Uživatel**“). Služby nespočívají ve zprostředkování zaměstnání.
- 1.4. Компани нь Европын Холбооны бус улс орны хувийн болон бусад хэвшилд ажил, хөдөлмөр эрхлээгүй ажил идэвхтэй хайгчдад (цаашид „**Хэрэглэгч**“ гэх) Үйлчилгээ үзүүлдэг. Уг Үйлчилгээг хөдөлмөр зуучлалын үйлчилгээ гэж үзэхгүй.
- 1.5. S ohledem na výše uvedené vydává Společnost - v souladu s ustanovením § 1751 odst. 1 zákona č. 89/2012 Sb., občanský zákoník, ve znění pozdějších předpisů (dále jen „**občanský zákoník**“) - tyto všeobecné obchodní podmínky (dále jen „**Podmínky**“), které upravují vzájemná práva a povinnosti ve smluvních vztazích mezi Společností a Uživatelem.
- 1.5. Хүчин төгөлдөр хэрэгжиж буй 89/2012 тоот Иргэний хууль, түүний нэмэлт, өөрчлөлтүүдийн тухай (цаашид „**Иргэний хууль**“ гэх) 1751-р зүйлийн 1-р заалтын дагуу Компани болон Хэрэглэгч хооронд үүсэх эрх, үүргийг зохицуулах - энэхүү ерөнхий нөхцөл (цаашид „**Нөхцөл**“ гэх) -ийг Компани бие даан боловсруулна.
- 1.6. Práva a povinnosti Společnosti a Uživatele, které nejsou výslovně upraveny těmito Podmínkami, se řídí příslušnými právními předpisy České republiky, zejména občanským zákoníkem, a právními předpisy Evropské unie.
- 1.6. Компани болон Хэрэглэгчийн энэхүү Нөхцөлд тодорхой заагаагүй эрх, үүргийг БНЧУ-ын холбогдох хууль тогтоомж, дээр дурдсан Иргэний хууль болон Европын Холбооны хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.7. Kontaktní údaje Společnosti jsou dostupné v čl. 9.4 těchto Podmínek a na Webových stránkách.
- 1.7. Компанийн холбоо барих мэдээллийг энэхүү Нөхцөлийн 9.4 -р заалт болон Веб сайтаас авах боломжтой.
- 1.8. Ustanovení těchto Podmínek jsou nedílnou součástí Smlouvy. Smlouva a Podmínky jsou vyhotoveny v českém jazyce. Smlouvu lze uzavřít v českém jazyce.
- 1.8. Энэхүү Нөхцөлийн заалтууд нь гэрээний салшгүй хэсэг байна. Гэрээ болон Нөхцөлийг чех хэлээр бэлтгэсэн байна. Гэрээг мөн чех хэлээр байгуулж болно.

2. Uživatelský účet

- 2.1. Uživatel si může registrací na Webových stránkách zdarma vytvořit svůj osobní profil, přistupovat do svého uživatelského rozhraní a získat přístup do Základní databáze (dále jen „**Uživatelský účet**“ a „**Registrovaný uživatel**“).

2. Хэрэглэгчийн бүртгэл

- 2.1. Хэрэглэгч Веб сайтад үнэ төлбөргүй бүртгүүлж хувийн профайлаа үүсгэн, хэрэглэгчийн интерфэйс рүү нэвтэрч, Үндсэн мэдээллийн санд (цаашид „**Хэрэглэгчийн бүртгэл**“ болон „**Бүртгэлтэй хэрэглэгч**“ гэх) нэвтрэх боломжтой болно.

2.2. Před provedením registrace je Uživatel povinen seznámit se s těmito Podmínkami. Provedením registrace vyjadřuje Uživatel svůj souhlas se zněním těchto Podmínek a zavazuje se je dodržovat. Pokud Uživatel se zněním těchto Podmínek nesouhlasí, je povinen neprodleně Webové stránky opustit a žádným způsobem Webové stránky nevyužívat.

2.3. Při registraci na Webových stránkách je Uživatel povinen uvádět správně a pravdivě všechny údaje. Údaje uvedené v Uživatelském účtu je Registrovaný uživatel při jakémkoliv jejich změně povinen aktualizovat bez zbytečného odkladu, nejpozději však do 10 dnů od jejich změny. Údaje uvedené Registrovaným uživatelem v Uživatelském účtu jsou Společností považovány za správné.

2.4. Po úspěšné registraci odešle Společnost Registrovanému uživateli na e-mailovou adresu, kterou při registraci uvedl, e-mailovou zprávu s odkazem pro dokončení registrace. Pokud Registrovaný uživatel klikne na tento odkaz, je registrace dokončena a Společnost mu zašle další e-mailovou zprávu s přihlašovacími údaji do Uživatelského účtu.

2.5. Přístup k Uživatelskému účtu je zabezpečen uživatelským jménem a heslem. Registrovaný uživatel je povinen zachovávat mlčenlivost ohledně informací nezbytných k přístupu do jeho Uživatelského účtu.

2.6. Registrovaný uživatel není oprávněn umožnit využívání Uživatelského účtu třetím osobám. Porušení tohoto ujednání je podstatným porušením Smlouvy a opravňuje Společnost k okamžitému zrušení Uživatelského účtu.

2.2. Хэрэглэгч бүртгүүлэхээсээ өмнө энэхүү Нөхцөлтэй бүрэн танилцах үүрэгтэй. Хэрэглэгч бүртгүүлэхдээ уг Нөхцөлийн зөвшөөрч байгаагаа илэрхийлж, цаашид дагаж мөрдөх үүрэгтэй. Хэрэглэгч Нөхцөлийг зөвшөөрөөгүй тохиолдолд Веб сайтаас нэн даруй гарч, цаашид ямар нэг зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.

2.3. Хэрэглэгч Веб сайтад бүртгүүлэхдээ хувийн болон бусад мэдээллийг үнэн зөв оруулах үүрэгтэй. Хэрэглэгчийн оруулсан аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд Бүртгэлтэй хэрэглэгч зохих мэдээллийг 10 хүртэл хоногийн дотор засаж шинэчлэх үүрэгтэй: Компани Бүртгэлтэй хэрэглэгчийн оруулсан мэдээллийг Компани үнэн зөв мэдээлэл гэж үзнэ.

2.4. Бүртгэлтэй хэрэглэгч амжилттай бүртгүүлсний дараа Компаниас бүртгэлээ дуусгах холбоос бүхий цахим шууданг Бүртгэлтэй хэрэглэгчийн заасан и-мэйл хаяг руу илгээнэ. Бүртгэлтэй хэрэглэгч тус линк дээр дарж бүртгэлээ баталгаажуулснаар Хэрэглэгчийн бүртгэлд нэвтрэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компаниас Хэрэглэгчийн заасан и-мэйл хаяг руу дахин илгээнэ.

2.5. Хэрэглэгчийн бүртгэл нэвтрэх хэрэглэгчийн нэр болон нууц үгээр хамгаалагдсан байна. Бүртгэлтэй хэрэглэгч өөрийн Хэрэглэгчийн бүртгэлд нэвтрэх нэр болон нууц үгийг нууцлах үүрэгтэй.

2.6. Бүртгэлтэй хэрэглэгч нь гуравдагч этгээдэд Хэрэглэгчийн бүртгэлийг ашиглах боломж олгох эрхгүй. Бүртгэлтэй хэрэглэгч гуравдагч этгээдэд Хэрэглэгчийн бүртгэлийг ашиглах боломж олгох нь Гэрээг ноцтой зөрчсөнд тооцогдох үйлдэл бөгөөд энэ тохиолдолд Компани урьдчилж мэдэгдэлгүй, бие даан шийдвэр гаргаж Хэрэглэгчийн бүртгэлийг нэн даруй цуцлах эрхтэй.

2.7. Registrovaný uživatel bere na vědomí a je srozuměn s tím, že Uživatelský účet nemusí být dostupný nepřetržitě, a to zejména s ohledem na nutnou údržbu hardwarového a softwarového vybavení Společnosti, popř. na nutnou údržbu hardwarového a softwarového vybavení třetích osob.

3. Poplatek, platební podmínky a uzavření Smlouvy

3.1. Registrovaný uživatel může čerpat i zpoplatněné služby spočívající v přístupu do Rozšířené databáze a k Informacím o imigračních povoleních (dále jen „**Zpoplatněná služba**“), a to za souhrnný poplatek ve výši **30 USD** (slovy: třicet amerických dolarů) (dále jen „**Poplatek**“). Okamžikem, kdy je Poplatek připsán na účet Společnosti, je mezi Společností a Registrovaným uživatelem uzavřena smlouva o poskytování služeb (dále jen „**Smlouva**“).

3.2. Služba je poskytována na počkání. Společnost nevydává písemné potvrzení o převzetí objednávky.

3.3. Náklady na zajištění a poskytování Služby (např. náklady na obsahové zajištění Informací o imigračních povoleních, udržování Webových stránek, náklady na provoz serverů apod.) nese Společnost. Uživatel nese náklady na internetové připojení za účelem čerpání Služeb.

3.4. Pokud se Registrovaný uživatel rozhodne čerpat Zpoplatněné služby, může uhradit Poplatek jedním z následujících způsobů:

(i) bezhotovostním převodem na účet Společnosti č. 9519212/0800, vedený u společnosti Česká spořitelna a.s. (dále jen „**účet Společnosti**“),

(ii) bezhotovostně prostřednictvím platebního systému, nebo

2.7. Компани эсвэл гуравдагч этгээдийн програм хангамж, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ зэргээс шалтгаалан Хэрэглэгчийн бүртгэлийн үйл ажиллагаа саатах, доголдохыг Бүртгэлтэй хэрэглэгч хүлээн зөвшөөрч байна.

3. Хураамж, төлбөрийн нөхцөл болон Гэрээ байгуулах

3.1. Бүртгэлтэй хэрэглэгч мөн Өргөтгөсөн мэдээллийн санд хандах, Цагаачлал буюу шилжин суурьшилтын зөвшөөрөл хүсэх, олгох тухай мэдээлэл авах зэрэг **30 ам.долларын** (үгээр: гучин америк доллар) нийт хураамжтай (цаашид „**Хураамж**“ гэх) төлбөртэй үйлчилгээ (цаашид „**Төлбөртэй үйлчилгээ**“ гэх) авч болно. Компанийн дансанд уг Хураамж орох даруй Компани болон Бүртгэлтэй Хэрэглэгчийн хооронд үйлчилгээ үзүүлэх, авах гэрээ (цаашид „**Гэрээ**“ гэх) байгуулагдана.

3.2. Компани Үйлчилгээг 24/7 горимд явуулна. Компанийн зүгээс захиалга хүлээн авсан тухай бичгээр баталгаажуулахгүй.

3.3. Компани Үйлчилгээ үзүүлэх зардлыг (жишээ нь Цагаачлал буюу шилжин суурьшилтын зөвшөөрлийн тухай мэдээлэл бүрдүүлэх зардал, Веб сайтын засвар үйлчилгээ, серверийн үйл ажиллагааны зардал гэх мэт) бүрэн хариуцдаг. Бүртгэлтэй хэрэглэгч Үйлчилгээ авах интернетийн зардлаа хариуцна.

3.4. Бүртгэлтэй хэрэглэгч Төлбөртэй үйлчилгээ авахаар шийдсэн тохиолдолд зохих төлбөрийг дараах аргуудаас сонгол төлнө. Үүнд:

(i) Ческа споржителна ХК (Česká spořitelna a.s.)-д бүртгэлтэй Компанийн 9519212/0800 тоот данс (цаашид „**Компанийн данс**“ гэх) руу шилжүүлэх,

(ii) бэлэн бусаар хэлбэрээр төлбөрийн системээр дамжуулан, эсвэл

(iii) bezhotovostně platební kartou.	(iii) төлбөрийн картаар.
3.5. Společnost nepožaduje od Registrovaného uživatele zálohu či jinou obdobnou platbu.	3.5. Компани нь Бүртгэгдсэн хэрэглэгчээс барьцаа болон бусад ижил төстэй төлбөр шаардахгүй.
3.6. Společnost neposkytuje záruku za jakost Služby nad rámec zákonných práv z vadného plnění.	3.6. Компани нь хууль ёсны эрхийнхээ хүрээнээс дээш доголдолтой гүйцэтгэлийн Үйлчилгээний чанарт баталгаа өгдөггүй.
3.7. Společnost přijímá platby pouze v měně USD (americký dolar). Zpoplatněnou službu poskytne Společnost Registrovanému uživateli bez zbytečného odkladu po připsání Poplatku na účet Společnosti.	3.7. Компани төлбөрийг зөвхөн USD (Америкийн доллар) -оор хүлээн авна. Бүртгэлтэй хэрэглэгч Компанийн дансанд төлбөрийг шилжүүлсний даруй Кампанийн зүгээс Бүртгэгдсэн хэрэглэгчдэд Төлбөртэй үйлчилгээ үзүүлнэ.
3.8. Poplatek není přizpůsobován osobě Registrovaného uživatele na základě automatizovaného rozhodování.	3.8. Хураамжийг бүртгэх, баталгаажуулах үйлдэл нь автомат бөгөөд Бүртгэлтэй хэрэглэгчийн онцлогийг харгалзахгүй болно.
3.9. V návaznosti na uzavření Smlouvy může Společnost Registrovanému uživateli poskytnout jako dodatečnou službu spočívající v tom, že mu jednou měsíčně zašle na e-mailovou adresu uvedenou v Uživatelském účtu (čl. 2.3 Podmínek), seznam volných pracovních míst v Registrovaným uživatelem vybraných členských státech Evropské unie. Seznam bude vytvořen na základě automatické komparace údajů uvedených Registrovaným uživatelem v Uživatelském účtu s údaji v Rozšířené databázi (dále jen „ Doplňková služba “). Doplnkovou službu Společnost poskytuje dobrovolně a vyhrazuje si právo ji kdykoliv změnit, pozastavit, nebo ukončit.	3.9. Гэрээ байгуулсны дараа Компани Европын холбооны гишүүн орнууд дахь ажлын байрны жагсаалтыг сард нэг удаа Бүртгэлтэй хэрэглэгчийн заасан цахим шуудангаар (Нөхцөлийн 2.3 -р заалт) Бүртгэлтэй хэрэглэгч рүү илгээх нэмэлт үйлчилгээг үзүүлж болно. Бүртгэлтэй хэрэглэгчийн хэрэглэгчийн бүртгэлд оруулсан мэдээллийг Өргөтгөсөн мэдээллийн сангийн өгөгдөлтэй автоматаар харьцуулж жагсаалт (цаашид „ Нэмэлт үйлчилгээ “ гэх) гаргана. Компани нэмэлт үйлчилгээг сайн дурын үндсэн дээр үзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд өөрчлөх, зогсоох, цуцлах эрхтэй.
3.10. Společnost je oprávněna kdykoliv změnit výši Poplatku. Jakákoli taková změna se nevztahuje na již uzavřené Smlouvy.	3.10. Компанийн зүгээс Хураамжийн хэмжээг шаардлагатай тохиолдолд өөрчлөх эрхтэй. Аливаа өөрчлөлт нь хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнд нөлөөлөхгүй.
4. Práva a povinnosti smluvních stran	4. Гэрээний оролцогч талуудын эрх, үүрэг
4.1. Společnost je povinna proti úhradě Poplatku poskytnout Registrovanému uživateli Zpoplatněnou službu.	4.1. Компани Хураамжийн төлбөр хүлээн авсны дараа Бүртгэлтэй хэрэглэгчид Төлбөртэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

- 4.2. Společnost se zavazuje usilovat o to, aby informace poskytnuté v souvislosti se Zpoplatněnou službou byly vždy aktuální a přesné. Společnost nicméně nezaručuje, že tyto informace budou vždy kompletní, aktuální a bezchybné a není odpovědná za jakoukoliv újmu, která by mohla vzniknout v důsledku spoléhání se na tyto informace.
- 4.3. Společnost je oprávněna kdykoliv aktualizovat a měnit obsah Webových stránek.
- 4.4. Společnost je oprávněna zrušit Uživatelský účet, a to zejména v případě, že Registrovaný uživatel svůj Uživatelský účet déle než 1 rok nevyužívá, či v případě, kdy Uživatel poruší své povinnosti z Podmínek nebo ze Smlouvy.
- 4.5. Registrovaný uživatel je oprávněn přistupovat za podmínek uvedených v těchto Podmínkách ke svému Uživatelskému účtu.
- 4.6. Registrovaný uživatel je oprávněn kdykoliv ukončit svůj Uživatelský účet.
- 4.7. Registrovanému uživateli může být doručováno na elektronickou adresu, kterou uvedl v Uživatelském účtu.
- 4.2. Компани нь Төлбөртэй үйлчилгээний хүрээнд үзүүлэх мэдээллийг цаг тутам шинэчилж, үнэн зөв байлгах үүрэгтэй. Гэсэн хэдий ч Компани нь тухайн мэдээллийн бүрэн байдал, цаг үеийн тухайд алдаагүй байх баталгаа өгөхгүй бөгөөд тухайн мэдээлэлд үндэслэн хийх аливаа үйлдлийн хохирлыг хариуцахгүй.
- 4.3. Компани Веб сайтын агуулга, мэдээллийг шаардлагатай тохиолдолд бие даан шинэчлэх, өөрчлөх эрхтэй.
- 4.4. Бүртгэлтэй хэрэглэгч бүртгэлээ 1 жилээс дээш хугацаагаар ашиглаагүй, эсвэл Хэрэглэгч Бүртгэлтэй Хэрэглэгч Нөхцөл эсвэл Гэрээнд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд Компани Бүртгэлтэй Хэрэглэгчийн бүртгэлийг цуцлах эрхтэй.
- 4.5. Бүртгэлтэй хэрэглэгч нь энэхүү Нөхцлийн дагуу өөрийн Хэрэглэгчийн бүртгэлд нэвтрэх эрхтэй.
- 4.6. Бүртгэлтэй хэрэглэгч хүссэн үедээ Хэрэглэгчийн бүртгэлээ цуцлах эрхтэй.
- 4.7. Бүртгэлтэй хэрэглэгчийн цахим хаягаар хэрэглэгчийн бүртгэл цуцлагдсан тухай мэдэглэл хүргэж болно.

5. Ochrana osobních údajů

- 5.1. Společnost je povinna zajistit bezpečnost osobních údajů Registrovaného uživatele a zpracovávat je v souladu s platnými právními předpisy, bližší informace jsou uvedeny v Zásadách ochrany osobních údajů Společnosti, které jsou dostupné na Webových stránkách.
- 5.2. Svou informační povinnost vůči Registrovanému uživateli ve smyslu článku 13 nařízení Evropského parlamentu a Rady č. 2016/679 o ochraně fyzických osob v souvislosti se zpracováním osobních údajů a o volném pohybu těchto údajů a o zrušení směrnice 95/46/ES (obecné nařízení o ochraně osobních údajů) související se zpracováním osobních údajů

5. Хувийн мэдээллийг хамгаалах

- 5.1. Компани Бүртгэлтэй Хэрэглэгчийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулах үүрэгтэй бөгөөд энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг Веб сайтад байрлуулсан Компанийн Хувийн Мэдээлэл Хамгаалах Ерөнхий Журамд дурдсан болно.
- 5.2. Компани Бүртгэлтэй хэрэглэгчийн өмнө мэдээллийн үүргээ Европын Парламент, Европын Холбооны Зөвлөлийн 2016/679 тоот журмын 13 дугаар зүйлд заасан Хүний хувийн мэдээллийн боловсруулалттай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай, хүний хувийн мэдээллийг дамжуулах, мөн Гэрээг биелүүлэх болон Нэмэлт үйлчилгээ үзүүлэх зорилгоор Бүртгэлтэй хэрэглэгчийн хувийн мэдээллийг

Registrovaného uživatele pro účely plnění Smlouvy a poskytnutí Dodatečné služby a pro účely plnění veřejnoprávních povinností Společnosti plní Společnost prostřednictvím zvláštního dokumentu uvedeného v předchozím článku těchto Podmínek.

6. Doba trvání Smlouvy

6.1. Smlouva je uzavírána na dobu určitou a je ukončena uplynutím jednoho roku ode dne uzavření Smlouvy. Případné dobrovolné poskytnutí Dodatečné služby Společností není pro Registrovaného uživatele, který uhradil Poplatek, bezdůvodným obohacením.

6.2. Registrovaný uživatel, který uhradil Poplatek, nemá v souladu s ustanovením § 1837 písm. a) občanského zákoníku právo odstoupit od Smlouvy, jestliže byly Služby v plném rozsahu poskytnuty. Pro úhradu Poplatku (pro uzavření Smlouvy) je vyžadováno, aby Registrovaný uživatel vyjádřil svůj výslovný souhlas se započítáním plnění před uplynutím lhůty pro odstoupení od smlouvy podle ustanovení § 1829 odst. 1 občanského zákoníku a s poučením, že poskytnutím plnění zaniká právo odstoupit od Smlouvy.

6.3. Žádná ze smluvních stran není oprávněna Smlouvu vypovědět.

7. Náhrada újmy

7.1. Společnost nenese odpovědnost za jakoukoliv újmu vzniklou v důsledku nesprávných, neaktuálních nebo neúplných informací poskytnutých Registrovaným uživatelem, v důsledku výpadku Webových stránek z důvodu technických problémů Společnosti nebo třetí osoby, ani v důsledku okolností mimo kontrolu Společnosti (vyšší moc).

боловсруулахтай холбоотой 95/46/ЕС (Хүний хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журам) удирдамжийг хүчингүй болгох тухай болон олон нийтийн хуулиар хүлээсэн үүргээ энэхүү Нөхцөлийн өмнөх зүйлд дурдсан тусгай баримт бичгээр дамжуулан гүйцэтгэнэ.

6. Гэрээний хугацаа

6.1. Гэрээг тодорхой хугацаатай байгуулах бөгөөд гэрээ байгуулсан өдрөөс хойш нэг жилийн дараа гэрээ дуусгавар болно. Компани нэмэлт үйлчилгээг сайн дурын үндсэн дээр үзүүлэх нь бөгөөд Бүртгэлтэй хэрэглэгчийн төлсөн Хураамжийг үндэслэлгүй хөрөнгөжих шалтгаан гэж үзэхгүй.

6.2. Компани Үйлчилгээг бүрэн хэмжээгээр үзүүлсэн тохиолдолд Хураамж төлсөн Бүртгэлтэй хэрэглэгч Иргэний хуулийн § 1837-ын а) -р заалтын дагуу Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээс татгалзах, Гэрээг цуцлах эрхгүй. Иргэний хуулийн §1829 зүйлийн 1-р заалтын дагуу Гэрээ байгуулахаас өмнө Гэрээг зогсоох, Гэрээнээс татгалзах эрхгүй гэсэн заалтыг шууд зөвшөөрч байгаа эсэхээ илэрхийлж баталгаажуулахыг Хураамжийн төлбөрийг төлөхийн (Гэрээ байгуулахын) өмнө Бүртгэлтэй хэрэглэгчээс шаардана.

6.3. Гэрээний талуудын аль нь ч Гэрээг цуцлах эрхгүй.

7. Хохирлын нөхөн төлбөр

7.1. Бүртгэлтэй хэрэглэгчийн буруу, хуучирсан, дутуу мэдээлэл өгсөн эсвэл Компанийн болон гуравдагч этгээдийн техникийн асуудлаас үүдэн Веб сайт ажиллахгүй болсны улмаас, эсвэл Компаниас үл хамаарах нөхцөлийн улмаас (давагдашгүй хүчин зүйл) улмаас учирсан хохирлыг Компани хариуцахгүй.

7.2. Společnost není odpovědná za jakoukoliv újmu vzniklou v souvislosti se způsobem, jakým Registrovaný uživatel naložil s informacemi získanými prostřednictvím Služeb. Společnost rovněž není odpovědná za úspěch či neúspěch Registrovaného uživatele v důsledku poskytnutí Služeb nebo Doplňkové služby při získávání imigračního povolení ani zaměstnání.

7.3. Registrovaný uživatel se zavazuje nahradit Společnosti jakoukoliv újmu, která by Společnosti vznikla v důsledku porušení těchto Podmínek Registrovaným uživatelem, a to zejména v důsledku porušení povinnosti poskytnout Společnosti správné, pravdivé a aktuální informace.

8. Práva z vadného plnění

8.1. Práva a povinnosti smluvních stran ohledně práv z vadného plnění se řídí příslušnými obecně závaznými právními předpisy, zejména ustanoveními § 1914 až 1925 občanského zákoníku a zákonem č. 634/1992 Sb., o ochraně spotřebitele, ve znění pozdějších předpisů.

8.2. Společnost odpovídá Registrovanému uživateli, který uhradil Poplatek, že Zpoplatněná služba při poskytnutí nemá vady. Zejména Společnost odpovídá Registrovanému uživateli, který uhradil Poplatek, že Služba odpovídá ujednanému popisu a druhu, jakož i jakosti a jiným ujednaným vlastnostem Služby.

8.3. Pokud Registrovaný uživatel, který uhradil Poplatek, zjistí, že Zpoplatněná služba má vadu, je povinen tuto vadu oznámit Společnosti bez zbytečného odkladu. Společnost je v takovém případě povinna vadu Zpoplatněné služby opravit, nebo doplnit, co chybí, a to ve lhůtě do 30 dnů ode dne, kdy jí bylo doručeno oznámení vady. Společnost neposkytuje slevu z Poplatku.

7.2. Бүртгэлтэй хэрэглэгч Үйлчилгээнд нэвтэрч олж авсан мэдээллийн дагуу яаж гүйцэтгэсэн үйлдлээс шалтгаалан үүссэн аливаа хохирлыг Компани бүх хэлбэрээр хариуцлага хүлээхгүй. Бүртгэлтэй хэрэглэгч Цагаачлал буюу шилжин суурьшилтын зөвшөөрөл хүсэх, олгох эсвэл ажилд орох талаар Үйлчилгээ эсвэл Нэмэлт үйлчилгээ үзүүлсэн амжилттай эсвэл амжилтгүй тохиолдолд Компани бүх хэлбэрээр хариуцлага хүлээхгүй.

7.3. Бүртгэлтэй хэрэглэгч энэхүү Нөхцөлд заасан эрх, үүргээ, ялангуяа Компанийг үнэн зөв, шинэчилсэн мэдээллээр хангах үүргээ зөрчсөний улмаас Компанид учирсан аливаа хохирлыг Бүртгэлтэй хэрэглэгч нөхөн төлөх үүрэгтэй.

8. Доголдолтой гүйцэтгэлийг нэхэмжлэх эрх

8.1. Гэрээлэгч Талуудын доголдолтой гүйцэтгэлийг нэхэмжлэх эрх, үүргийг холбогдох нийтээр дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтаар, тухайлбал Иргэний хуулийн 1914-1925 дугаар зүйл, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, нэмэлт өөрчлөлт, хуулийн эмхэтгэлийн 634/1992 тоот хуулийн заалтуудаар зохицуулна.

8.2. Компани Хураамж төлсөн Бүртгэлтэй хэрэглэгчид Төлбөртэй үйлчилгээ үзүүлэхдээ ямар нэг доголдол гаргахгүй байх үүр хүлээнэ. Ялангуяа Үйлчилгээний төрөл, чанар болон талуудын тохиролцсон бусад шинж чанар бүрэн хангагдаж байгаа эсэхийг төлбөр төлсөн Бүртгэлтэй Хэрэглэгчийн өмнө Компани бүрэн хариуцна.

8.3. Төлбөр төлсөн Бүртгэлтэй хэрэглэгч Төлбөртэй үйлчилгээ алдаатай байгааг олж мэдсэн тохиолдолд энэ тухайн алдааны талаар Компанид цаг алдалгүй мэдэгдэх үүрэгтэй. Бүртгэлтэй хэрэглэгч ийнхүү мэдэгдсэн тохиолдолд Компани төлбөртэй үйлчилгээний алдааг мэдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор алдааг арилгах, эсвэл дутуу зүйлсийг нэмж оруулах үүрэгтэй. Компани нь Хураамжид хэсэгчлэн болон бүрэн дүнгээр хөнгөлөлт үзүүлэхгүй.

8.4. Společnost neodpovídá za vady Základní databáze a Doplnkové služby, neboť tyto jsou Společností poskytovány dobrovolně.

8.4. Компани Үндсэн мэдээллийн сан болон Нэмэлт үйлчилгээг сайн дурын үндсэн дээр үзүүлдэг учир Үндсэн мэдээллийн сан болон Нэмэлт үйлчилгээнд гарсан доголдлыг хариуцахгүй.

9. Závěrečná ujednání

9. Эцсийн зохицуулалт

9.1. Pokud vztah založený Smlouvou obsahuje mezinárodní (zahraniční) prvek, pak smluvní strany sjednávají, že se vztah řídí právním řádem České republiky. Volbou práva podle předchozí věty není Registrovaný uživatel, který je spotřebitelem, zbaven ochrany, kterou mu poskytují ustanovení právního řádu, od nichž se nelze smluvně odchýlit a jež by se v případě absence volby práva jinak použila podle ustanovení článku 6 odst. 1 nařízení Evropského parlamentu a Rady (ES) č. 593/2008 ze dne 17. června 2008 o právu rozhodném pro smluvní závazkové vztahy (Řím I).

9.1. Гэрээгээр тогтоосон харилцаанд олон улсын (гадаад) хүчин зүйлс нөлөөлж байгаа тохиолдолд Гэрээний Талууд Гэрээгээр тогтсон харилцааг Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна гэж тохиролцов. Ийнхүү тохиролцох нь Бүртгэлтэй хэрэглэгчийг олон улсын болон БНЧУ-ын хууль, журамд заасан эрх, үүргээс чөлөөлөх, чөлөөлөгдөх, Гэрээнд заасан эрх, үүргээс татгалзах үндэслэл болохгүй. Гэрээгээр тогтсон харилцааг зохицуулах хуулийг заагаагүй тохиолдолд 2008 оны 6-р сарын 17-ны өдрийн 593/2008 тоот Европын Парламент, Европын Холбооны Зөвлөлийн Гэрээгээр хүлээх үүргийн тухай (Řím I) журмын 6 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн дагуу хуулийг сонгон мөрдөнө.

9.2. Je-li některé ujednání těchto Podmínek neplatné nebo neúčinné, nebo se takovým stane, namísto takového ujednání nastoupí ujednání, jehož smysl se neplatnému nebo neúčinnému ujednání co nejvíce přibližuje. Neplatností nebo neúčinností jednoho ujednání není dotčena platnost či účinnost ostatních ujednání Podmínek.

9.2. Энэхүү Нөхцөлийн аль нэг зохицуулалт хэсэгчлэн эсвэл нийтдээ түтгэлзүүлсэн эсвэл хүчингүй болсон тохиолдолд тухайн хэсэгчлэн эсвэл нийтдээ түтгэлзүүлсэн эсвэл хүчингүй болсон зохицуулалттай төстэй, ижил утгатай зохицуулалтаар орлуулж мөрдлөг болгоно. Нэг зохицуулалт хэсэгчлэн эсвэл нийтдээ түтгэлзүүлсэн эсвэл хүчингүй болох нь Нөхцөлийн бусад зохицуулалтуудад хэсэгчлэн болон нийтэд нь нөлөөлөхгүй, түтгэлзүүлэхгүй, хүчин төгөлдөр болгохгүй.

9.3. Smlouva včetně Podmínek je Společností archivována v elektronické podobě a není přístupná.

9.3. Компани Нөхцөлийг Гэрээний хамт цахим хэлбэрээр архивлан хадгалах бөгөөд цахим архив руу тусгай эрх бүхий этгээдээс өөр хүн нэвтрэх боломжгүй байна.

9.4. Kontaktní údaje Společnosti: adresa sídla Žerotínova 503/5, České Budějovice 4, 370 04 České Budějovice, adresa elektronické pošty info@simplegate.eu, telefonní číslo +420 800 222 221. Společnost neposkytuje jiný prostředek on-line komunikace.

9.4. Компанийн холбоо барих хаяг: бүртгэлтэй албан хаяг Ческе Будееовице хот, Зип код 37004, Ческе Будееовице 4, Жеротинова гудамж 503/5 тоот (Žerotínova 503/5, České Budějovice 4, 370 04 České Budějovice), цахим шуудангийн хаяг info@simplegate.eu, утасны дугаар +420 800 222 221. Тус компани нь онлайн харилцааны өөр хэрэгслийг санал

болгодоггүй.

9.5. Tyto Podmínky a Smlouva mohou být pro Uživatele přeloženy do jiných jazyků. V případě rozdílů mezi těmito překlady a verzemi v českém jazyce mají přednost česká znění.

9.5. Эдгээр Нөхцөл, Гэрээг Хэрэглэгчдэд зориулан бусад хэлээр орчуулж болно. Тухайн орчуулга болон чех хэл дээрх хувилбарын хооронд ялгаа байгаа тохиолдолд чех хувилбар нь давуу эрхтэй.

9.6. Znění těchto Podmínek může Společnost měnit či doplňovat. Tímto nejsou dotčena práva a povinnosti vzniklá po dobu účinnosti předchozího znění těchto Podmínek.

9.6. Энэхүү Нөхцөлийн үг хэллэгийг Компани засаж өөрчилж, нэмж, хасаж болно. Ийнхүү засвар өөрчлөлт оруулах нь Нөхцөлийн өмнөх хувилбар хүчинтэй байх хугацаанд үүссэн эрх, үүрэгт нөлөөлөхгүй.

9.7. Pro případ jakýchkoliv sporů vzniklých v souvislosti se Smlouvou, s Podmínkami nebo se Zásadami ochrany osobních údajů se smluvní strany dohodly na tom, že pro řešení takových sporů budou příslušné soudy České republiky.

9.7. Гэрээ, Нөхцөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалахад баримтлах зарчимтай холбоотой аливаа маргаан гарсан тохиолдолд тухайн маргааныг Бүгд Найрамдах Чех Улсын холбогдох шүүхэд мэдүүлж шийдвэрлүүлнэ гэж Гэрээний Талууд харилцан тохиролцов.

Datum: 13.9.2023

Огноо: 2023 оны 9-р сарын 13-ны өдөр

MONTO, s.r.o.

МОНТО ХХК (MONTO, s.r.o.)